

Төсөл

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчидийн
__ оны ээлжит __ дүгээр
хуралдааны хоёрдугаар хавсралт

Хамгаалалтад авсан газарт хэрэгжүүлэх

үйл ажиллагааны горим

Хэнтий аймгийн Чингис хотын төвлөрсөн усан хангамжийн нөөц батлагдсан газрын доорх усан хангамжийн эх үүсвэр ордыг өнөөгийн, түүнчлэн алс хэтийн өсөн нэмэгдэж байгаа усны хэрэгцээ, Чингис хотын ард иргэдийг эрүүл аюулгүй, баталгаат усаар хангахын тулд газрын доорх усан хангамжийн эх үүсвэрийн орд газрыг орон нутгийн хамгаалалтад нэг тэргүүнд авах үндэслэл болж байна.

Нэг. Зорилго

Чингис хотын төвлөрсөн усан хангамжийн нөөц батлагдсан газрын доорх усан хангамжийн эх үүсвэр ордыг өнөөгийн, түүнчлэн алс хэтийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ, Чингис хотын ард иргэдийг эрүүл, аюулгүй баталгаат усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглалт, хамгаалалттай холбогдсон аливаа үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах зорилгоор Чингис хотын төвлөрсөн усан хангамжийн нөөц тогтоогдсон газрын доорх усны орд газарт Хэрлэн, Мөрөн, Баянхутаг сумдын тодорхой нутаг дэвсгэр хамаарч тухайн газрын доорх ус, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хамгаалалтын бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг тогтоох зорилгоор хамгаалалтад авсан газрыг хэлнэ.

2.2. Төвлөрсөн усан хангамжийн нөөц тогтоогдсон газрын доорх орд газарт Чингис хотын төвлөрсөн усан хангамжийн өнөөгийн ус авах байгууламжийн дэвгэр талбайд болон түүний хажуу жигүүрийн зэргэлдээх бүсэд газрын доорх усны ашиглалтын нөөц батлагдсан газрын доорх усан хангамжийн эх үүсвэр ордыг төрийн зохицуулалтад байна.

2.3. Хэрлэн голын 1-р дэнжид хамаарах дотоод тэжээгдлийн муж болох Чингис хотын төвлөрсөн усан хангамжийн өнөөгийн ус авах байгууламжийн дэвгэр талбайд болон түүний хажуу жигүүрийн зэргэлдээх бүсэд газрын доорх усны ашиглалтын нөөц батлагдсан газрын доорх усан хангамжийн эх үүсвэр орд газар нутгийн хамгаалалттай холбогдсон үйл ажиллагааг Монгол улсын Усны тухай хууль, Тусгай хамгаалалттай

газрын дүрэм, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын дагуу хариуцана.

2.4. Холбогдох сумын Засаг даргын тамгын газар нь доройтсон газрыг хамгаалахад өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгууллага иргэд, малчдыг идэвхитэй оролцуулах үүрэг хүлээнэ.

2.5. Тухайн нутаг дэвсгэрт Байгаль хамгаалагчийг мэргэжлийн удирдлага, техник хэрэгслээр хангаж, ажил үүргийнх нь биелэлтэд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ус хангагч байгууллага хяналт тавьж ажиллана.

2.6. Усан хангамжийн нөөц тогтоогдсон газрын доорх орд газарт газрын хэвлийг хамгаалах, ургамал амьтны өсч үржих, таатай нөхцлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг арилгах зэрэг байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авна.

Гурав. Хамгаалалттай газарт зөвшөөрөх үйл ажиллагаа

3.1. Аймгийн орон нутгийн хамгаалалтанд авсан Чингис хотын усан хангамжийн газрын доорх нөөц тогтоогдсон орд газар усны эх үүсвэрийн тэжээгдлийн муж болох Хэрлэн голын эрэг дагуух газарт хэрэгжүүлэхийн зэрэгцээ дор дурьдсан үйл ажиллагааг явуулна

- 3.1.1. Тухайн орон нутгийн хамгаалалтанд авсан газар нутагт усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх
- 3.1.2. Ус хангамжийн барилга байгууламжид өргөтгөх, засварлах, барих ажил хийхдээ байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх
- 3.1.3. Хамгаалалтын бүсийн талбайг тогтмол цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж, хөнөөлт шавж мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар механик аргаар хийж гүйцэтгэх
- 3.1.4. Хяналт-шинжилгээний цооног гаргах, хяналт-шинжилгээ явуулах
- 3.1.5. Уламжлалт аргаар мал бэлчээх
- 3.1.6. Хэрлэн голын эрэг дагуух татмын доройтсон газарт төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мод бут тарих, ургамалжуулах
- 3.1.7. Зөвшөөрөлтэйгөөр ахуйн зориулалтаар загас барих

Дөрөв. Хамгаалалттай газарт хориглох үйл ажиллагаа

4.1. Аймгийн хамгаалалттай газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- 4.1.1. Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис, бүх төрлийн бордоо, пестицид хадгалах, ашиглах;
- 4.1.2. Зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих, ан амьтан агнах

- 4.1.3 Машин техник угаах, хатуу, шингэн хог хаягдал хаях, шингэн хаягдлын сан байгуулах, хог хаягдлын цэг байршуулах, хөрс ус, агаар бохирдуулах
- 4.1.4 Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах
- 4.1.5 Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах
- 4.1.6 Туслах аж ахуй эрхлэх, бэлчээх
- 4.1.7 Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах
- 4.1.8 Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох
- 4.1.9 Усан хангамжийн зориулалтаар ашиглаж байсан, ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах
- 4.1.10 Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах
- 4.1.11 Ус ашиглах, хэрэглэх зорилалтаар худаг, цооног өрөмдөх, энгийн уурхайн, гар худаг гаргах
- 4.1.12 Хэрлэн голын эрэг дагуух доройтсон газар нутаг болон бургасанд түймэр гаргах
- 4.1.13 Хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд байгаль орчинд сөргөөр нөлөөлөх арга техник, бодис хэрэглэх
- 4.1.14 Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох
- 4.1.15 Шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажил явуулах

Тав. Хамгаалалттай газрын санхүүжилт

5.1. Улс, аймаг, сумын орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, ус хангагч байгууллага

5.2. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив тусламж

Зургаа. Тавих хяналт, тайлагнах

6.1. Холбогдох аймаг сумын Засаг даргын тухайн хамгаалалтын газарт энэ горимын дагуу үйл ажиллагааг явуулж, уг горимыг зөрчсөн гэм буруутай этгээдэд байгаль орчны бүх шатны байцаагчид эрх хэмжээнийхээ хүрээнд Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дүрэм, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

6.2. Хамгаалалтанд авсан газарт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар тухайн орон нутгийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч жил бүрийн 12 сарын 10-нд аймгийн Засаг даргад тайлагнана.